



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хуульчдын подкаст" студийн үйл ажиллагааны журмыг 1 дүгээр хавсралтаар, "Хуульчдын подкаст" студийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг 2 дугаар хавсралтаар, түрээсийн үйлчилгээний хөлсийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус подкаст студийн хэвийн үйл ажиллагааг ханган, батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга /В.Энхтамир/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Т.Галбадрах/-д үүрэг болгосугай


ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

Захирлын тушаал 2021

101-001870



“ХУУЛЬЧДЫН ПОДКАСТ” СТУДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1.Хуульчдын подкаст студи /цаашид “Студи” гэх/ нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвөөс иргэд, олон нийтэд эрх зүйн мэдлэг олгох, мэдээлэл түгээх чиг үүргийн нэг хэсэг бөгөөд студийн үйл ажиллагаа, түүнийг ашиглахтай холбогдон үүссэн харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2.Тус хүрээлэнгийн албан хаагч, студийн мэргэжилтэн, сэтгүүлч, хуульчид, хамтран ажиллах байгууллага, хувь хүн энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.3.Энэхүү журмын хэрэгжилтийг Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга хангаж ажиллана.

Хоёр.Журмын нэр томъёоны тодорхойлолт

- 2.1.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1. “Тоног төхөөрөмж” гэж гэрэлтүүлэг, камер, камерийн иж бүрдэл, микрофон, зөөврийн микрофон тэдгээрийн систем, дуран, хөл, санамжийн карт, гэрэл, чихэвч, хүлээн авагч, компьютер хангамж болон бусад дагалдах хэрэгслүүдийг;
 - 2.1.2. “Контент” гэж студийн тоног төхөөрөмжийг ашиглан хийгдсэн видео, аудио мэдээ, мэдээлэл, тэдгээрийн цахим өгөгдлийг;
 - 2.1.3. “Түрээслүүлэх” гэж иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн подкаст студи ашиглах саналыг хүлээн авч, түрээсийн гэрээ байгуулж хамтран ажиллаж подкаст студи болон тоног төхөөрөмжийг төлбөртэй ашиглуулах;
 - 2.1.4. “Студийн ажилтан” гэж студийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах, подкаст нэвтрүүлэг бэлтгэх үүрэг хүлээсэн мэргэжилтэн;
 - 2.1.5. “Түрээслэгч” гэж студид подкастнэвтрүүлэг хийх, төсөл хэрэгжүүлэхээр захиалга өгч гэрээ байгуулсан хувь хүн, байгууллагыг;
 - 2.1.6. “Техник эзэмшигч” гэж студийн тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу хүлээн авсан, захиалгын хуудсанд гарын үсэг зурсан этгээдийг.

Гурав.Студийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

- 3.1.Студийн өдөр тутмын үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгон ажиллана.
 - 3.1.1. Байгууллагын нэр хүндийг эрхэмлэх;
 - 3.1.2. Хууль зүйн үндэслэлтэй, үнэн зөв мэдээ, мэдээллийг бэлтгэх, түгээх;
 - 3.1.3. Мэргэжлийн өндөр түвшинд, чанартай бүтээл хийх;

- 3.1.4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн хэм хэмжээ, соёл, дэг журмыг сахих, байгууллагын хөрөнгийг хайр, гамтай ашиглах.

Дөрөв.Подкаст студийн үйл ажиллагаа

- 4.1. Студи нь хууль, эрх зүйн чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн подкаст, нэвтрүүлгийг бүтээх ба подкастын төлөвлөгөөг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн даргад хянуулж, захирлаар батлуулна.
- 4.2. Студи нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
- 4.2.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, сурталчилгааны ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх;
- 4.2.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд подкаст, нэвтрүүлэг хийх;
- 4.2.3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн захиалгаар контент бэлтгэн нийтэд хүргэх;
- 4.2.4. Бусад хэлбэрээр иргэд, албан байгууллагад түрээслүүлэх.
- 4.3. Аливаа хувь хүн, байгууллага студийн өрөө, тоног төхөөрөмжийг ашиглахдаа энэхүү журамтай урьдчилан танилцсан байна.

Тав.Подкаст студийн ашиглалт

- 5.1. Студийн өрөө, тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн даргад танилцуулж, хүрээлэнгийн захирлаас зөвшөөрөл авсан байна.
- 5.2. Студийн тоног төхөөрөмжийг зөвхөн студийн орчинд ашиглах бөгөөд тоног төхөөрөмжийг студизс өөр газар байрлуулан ашиглах тохиолдолд хүрээлэнгийн захирлаас зөвшөөрөл авна.
- 5.3. Студийг хууль, эрх зүйн чиглэлээр олон нийтэд мэдээ, мэдээлэл түгээх болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор байгууллага, хувь хүнд төлбөртэйгөөр ашиглуулж болно.
- 5.4. Студийг урьдчилан захиалга өгч, зөвшөөрөл авсан байгууллага, хувь хүнд хуваарийн дагуу ашиглуулна.
- 5.4.1. Студи ашиглах захиалгыг 2-5 хоногийн өмнө авна. Захиалгыг өөрийн биеэр ирэх болон утас, мэйлээр өгч болно. /Утсаар холбогдож өгсөн тохиолдолд тэмдэглэл үйлдэж баримтжуулна/.
- 5.4.2. Захиалга өгснөөс хойш 3 хоногийн дотор баталгаажуулж, студийн мэргэжилтэнтэй гэрээ байгуулж хүрээлэнгийн захирлаар батлуулна.
- 5.5. Студи болон тоног төхөөрөмжийг бусдад ашиглуулахдаа түрээсийн гэрээ байгуулна.
- 5.6. Студи болон тоног төхөөрөмжийн ашиглалтын төлбөрийг түрээсийн гэрээгээр тохиролцоно. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагад хөнгөлөлттэй үнээр ашиглуулж болно. .
- 5.7. Хуваарьт цагтаа ирээгүй болон ирэхгүй шалтгаанаа урьдчилан мэдэгдээгүйн улмаас тухайн цагийг ашиглаагүй өнгөрсөн бол түрээсийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

- 5.8. Студийн ажилтнаас студийн өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгаж хүлээн авна.
- 5.9. Студийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан хуудсанд гарын үсэг зурж, студийн журамтай танилцсан байна.
- 5.10. Студийн өрөө, тоног төхөөрөмжийг ашиглагч, техник эзэмшигч нь тоног төхөөрөмжтэй анхаарал болгоомжтой харьцаж, аливаа гэмтэл учрахаас урьдчилан сэргийлж ажиллана.
- 5.11. Студийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг асааж, унтраах ажилд бэлтгэх, ашиглахдаа төхөөрөмж нэг бүрийн ашиглалтын зааврыг мөрдөж ажиллана.
- 5.12. Тоног төхөөрөмж ажиллаж байх үед ямар нэгэн саатал гарвал студийн ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.
- 5.13. Түрээслэгч нь студийг зориулалтын дагуу ашиглаж, хүлээн авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Зургаа.Студийн үйл ажиллагаанд хориглох зүйл

- 6.1. Студийн үйл ажиллагаа, ашиглалтад дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 6.1.1. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг эзэнгүй, ил задгай орхих;
- 6.1.2. Тоног төхөөрөмжийн байршлыг солих, тохиргоог өөрчлөх, задлах, зөвшөөрөлгүй засах, тоног төхөөрөмж бүрэн унтраагүй үед салгаж, залгах;
- 6.1.3. Студийн өрөөнд хоол, хүнсний зүйл идэх, тоног төхөөрөмж дээр шингэн зүйл тавих, асгах;
- 6.1.4. Студийн өрөөнд архи, согтууруулах ундаа хэрэглэх;
- 6.1.5. Зөвшөөрөгдөөгүй бичлэг, ажил үйлчилгээг студид зохион байгуулах, захиалгат бүтээл, нэвтрүүлэг хийх, удирдлагын зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмж дур мэдэн ашиглахыг хатуу хориглоно.

Долоо.Студийн ажилтны үүрэг, хариуцлага

- 7.1. Студийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа Хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга болон захиралд тайлагнана.
- 7.2. Студийн ажилтан нь дараах үүрэг, хариуцлагыг хүлээж ажиллана. Үүнд:
- 7.2.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг технологийн боломжийг ашиглан үр дүнтэй, хүртээмжтэй арга, хэлбэрээр зохион байгуулах;
- 7.2.2. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах чиглэлээр подкаст, нэвтрүүлэг бэлтгэх ажлыг зохион байгуулах;
- 7.2.3. Төрийн болон төрийн бус байгууллагын захиалгаар контент бэлтгэх;
- 7.2.4. Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны төрөл бүрийн арга, хэлбэр, бусдын сайн жишиг, шинэлэг туршлагыг судалж үйл ажиллагаандаа нэвтрүүлж, шинийг эрэлхийлж ажиллах;
- 7.2.5. Студид үйл ажиллагаа явуулахдаа байгууллагын нийтлэг үнэт зүйл, баримтлах зарчмыг эрхэмлэн ажиллах ба дүрэмд заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;

- 7.2.6. Студийн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар заавар, зөвлөгөө өгөх;
- 7.2.7. Студийн тоног төхөөрөмжийг бусдад ашиглуулах болон өөр газар шилжүүлэх тухай бүрд бүртгэл хөтлөх, хяналт тавих
- 7.2.8. Студид ажиллах цагийн хуваарь гаргах, иргэд болон бусад байгууллагаас захиалга хүлээн авах, захиалгын гэрээг боловсруулах, зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулах
- 7.2.9. Студийн ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу студийн үйл ажиллагаа явуулахад хэрэглэгдэх тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, бэлэн байдлыг ханган ажиллах, эд хөрөнгийг хамгаалах, гал усны болон бусад аюулаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Найм.Бусад

- 8.1. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүрээлэнгийн захиралд уламжилж шийдвэрлүүлнэ.
- 8.2. Энэхүү журмын 1.2-т заасан этгээд нь хууль тогтоомж, энэхүү журмыг чанд мөрдөж ажиллана.
- 8.3. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг бүрэн хүлээнэ.



“ХУУЛЬЧДЫН ПОДКАСТ” СТУДИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2021 оны ... сарын ... өдөр

No

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Хууль зүйн үндэсний хүрээлэн /цаашид түрээслүүлэгч гэх/, түүнийг төлөөлж Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга В.Энхтамир, нөгөө талаас /цаашид түрээслэгч гэх/ түүнийг төлөөлж..... /цаашид талууд гэх/ Иргэний хуулийн 318-326 дугаар зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ҮНЭ

- 1.1. Түрээслүүлэгч өөрийн байрны подкаст студийг түрээслэгч талд 2021 оныдүгээр сарын ...-ны өдрөөс 2021 оны дүгээр сарын-ны өдрийг хүртэл өдрийн цаг, нийт цагийн (хэлэлцүүлэг, сургалт, нэвтрүүлэг)..... явуулахад зориулан ашиглуулна.
- 1.2. Түрээслэгч нь гэрээний 2 дугаар зүйлд заасан хугацаанд түрээсийн төлбөрийг төлнө.
- 1.3. Студийн нэг цагийн түрээсийн төлбөр төгрөг байна. Студийн түрээсийн төлөвлөсөн цагаас хэтэрсэн тохиолдолд 30 минут тутамд 30 000 төгрөгийн нэмэлт төлбөр тооцно.
- 1.4. Подкаст студийн төхөөрөмжийг түрээслүүлэгчийн подкаст студиэс өөр бусад танхимын хамт түрээслэх бол гэрээний 1.3 дахь хэсэгт заасан төлбөр дээр нэмж тухайн танхимын түрээсийн үнийг төлнө.

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1. Түрээслэгч тал студи түрээслэх захиалгыг тус хүрээлэнгийн студийн мэргэжилтэнд урьдчилан хүргүүлсэн байна.
- 2.2. Студийн мэргэжилтэн захиалгыг хүлээн авч, төлбөрийн нэхэмжлэлийг санхүүгийн эрх бүхий ажилтнаар бичилт, баталгаажилтыг хийлгэн түрээслэгч талд хүргүүлнэ. Түрээслэгч нь нэхэмжлэлийг үндэслэн нийт цагийн (.....) төлбөрийг Төрийн сангийн 100900012009 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.3. Түрээсийн төлбөрийг 100 хувь урьдчилан төлснөөр тухайн захиалга баталгаажиж, студийг ашиглах эрх нээгдэнэ.
- 2.4. Захиалгыг баталгаажуулаагүйгээс үүдэн гарах аливаа үр дагаврыг түрээслүүлэгч тал хариуцахгүй.
- 2.5. Баталгаажсан захиалгыг түрээслэгчийн санаачилгаар цуцлах тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө мэдэгдсэн байна. Хугацаа тулгаж буюу ажлын 2 хоногийн дотор цуцалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг суутгана.

ГУРАВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Түрээслүүлэгч нь студийн ширээ, сандал, самбар зэрэг биет байдлын доголдолгүй эд хөрөнгийг түрээслэгчид хүлээлгэн өгч, зохион байгуулж байгаа хүмүүсийг саадгүй нэвтрүүлж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангана.
- 3.2. Хүлээлцсэн эд хөрөнгийн цаашид үүсэх доголдлыг түрээслүүлэгч тал хариуцахгүй. Гагцхүү цахилгаан, дулаан, сантехник, барилга инженерийн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагаа алдагдсан буюу түрээслэгчийн буруугүйгээр гарсан эвдрэл гэмтлийг нэн даруй засварлах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хэрэв энэ төрлийн эвдрэл, гэмтлийн шинж байдал илрэхэд түрээслэгчийн зүгээс шаардлагатай арга хэмжээ аваагүйн улмаас түрээслүүлэгчид хохирол учирвал тэрхүү хохирлыг буруутай тал нөхөн барагдуулна.
- 3.3. Студийг ашиглаж дуусах үед түрээслүүлэгч тал хүлээлгэн өгсөн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг нягталж хүлээн авна.
- 3.4. Түрээсийн эд хөрөнгөнд учирсан эвдрэл, гэмтлийн засвар, үйлчилгээг буруутай тал хариуцна.
- 3.5. Түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчих, түрээслүүлэгчийн эд хөрөнгийг бусдад хууль бусаар шилжүүлэх, төлбөрийн чадваргүй болох, эсхүл эд хөрөнгө эзэмших чадваргүй болох зэрэг тохиолдолд гэрээг дангаараа цуцлах, учирсан хохирлыг түрээслэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 3.6. Студийг эзэнгүй орхих, цахилгааны аюулгүй ажиллагаа зөрчих зэрэг түрээслэгчийн хайхрамжгүй үйлдлийн улмаас түрээслүүлэгчийн болон үйл ажиллагаанд хамрагдаж буй хүмүүсийн эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд хохирлыг түрээслэгчээс шаардах эрхтэй.

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 "Хуульчдын подкаст" студийн үйл ажиллагааны журамтай урьдчилан танилцсан байх үүрэгтэй.
- 4.2 Түрээслүүлэгчээс хүлээлгэн өгсөн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 4.3 Түрээслэгчийн буруутай үйлдлийн улмаас түрээслүүлэгчийн эд хөрөнгөнд учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 4.4 Түрээсийн төлбөрийг гэрээгээр тохиролцсон хугацаанд төлнө.
- 4.5 Түрээсийн байрыг гэрээгээр тохиролцсоноос бусад нөхцөлөөр эзэмшиж ашиглахгүй байх, гуравдагч этгээдэд давхар түрээслэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 4.6 Студийн техник, тоног төхөөрөмж болон бусад гэрээний зүйлд түрээслэгчийн буруутай бус үйлдлийн улмаас гэнэтийн нөхцөл байдал буюу осол, эвдрэл, гэмтлийн шинж илэрвэл энэ тухайгаа түрээслүүлэгч буюу түүний захиргаанд нэн даруй мэдэгдэнэ. Түрээслүүлэгчийн захиргаанд нэн даруй мэдэгдэж яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжоор хангаагүйн улмаас түрээслүүлэгчид хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг түрээслэгч бүрэн хариуцна.
- 4.7 Ажил үүргээ хэвийн явуулах нөхцөл, бололцоогоор хангуулахтай холбогдсон аливаа шаардлагатай асуудлаар түрээслүүлэгчид санал, хүсэлт тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 4.8 Гэрээ дуусгавар болоход хүлээн авсан эд хөрөнгийг түрээслэгчид бүрэн, бүтэн хүлээлгэж өгнө.

ТАВ. БУСАД

- 5.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 5.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг өөрчилж, цуцалж дуусгавар болгож болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг талууд ажлын 5 хоногийн дотор хянан албажуулж хавсралтаар баталгаажуулна.
- 5.3. Гэрээг хоёр хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгалах ба хувь тус бүр хууль зүйн хувьд хүчин чадалтай байна.
- 5.4. Гэрээтэй холбогдож маргаан үүсвэл талууд хэлцлийн аргаар, эвийн журмаар зохицуулахыг эрхэмлэх бөгөөд эс зөвшилцвөл шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ТҮРЭЭСЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Хууль зүйн сургалт, мэдээлэл,
сурталчилгааны төвийн дарга

...../В.Энхтамир/

Утас: 315735

И-мэйл:


.....

.....

...../...../

Утас:

И-мэйл:



“Хуульчдын подкаст” студийн түрээсийн үйлчилгээний хөлс

№	Нөхцөл	Үнэ (төг.)
1	1 цагийн түрээсийн хөлс	70.000
2	Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллага болон Монголын хуульчдын холбоо	50 хүртэлх хувийн хөнгөлөлт үзүүлж болно.
3	Студид бэлтгэсэн контентыг эвлүүлэх ажлын үйлчилгээний хөлс, 1 контент	Аудио-50.000 Видео-100.000